

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/27/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.20 № 01/66
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоолын дагуу албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвт зардлыг 101,868.5 мянган төгрөгөөр хэмнэсэн ба оны эцэст зарцуулаагүй 105,560.4 мянган төгрөгийг, улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>161,898,823.27</u>	<u>161,302,935.09</u>
33	АВЛАГА	63,403.77	00.00
335	Бусад авлага	63,403.77	00.00
3351	Байгууллагаас авах авлага	43,574.97	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	19,828.80	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	161,835,419.50	161,302,935.09
351	Түүхий эд материал	162,500.00	761,146.59
35130	Эм боох материал	162,500.00	761,146.59
354	Хангамжийн материал	124,582,919.50	130,441,788.50
35410	Бичиг хэргийн материал	4,779,488.00	4,020,507.00
35420	Аж ахуйн материал	59,937,717.00	60,436,657.00
35430	Сэлбэг хэрэгсэл	267,939.50	267,939.50
35450	Барилгын засварын материал	56,693,555.00	56,391,605.00
35460	Хүнсний материал	2,680,220.00	8,720,080.00
35470	Бусад хангамжийн материал	224,000.00	605,000.00
35600	Мал амьтад	37,090,000.00	30,100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,162,507,432.17</u>	<u>2,022,360,790.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,162,507,432.17	2,022,360,790.99
392	Биет хөрөнгө	1,529,282,781.31	1,398,074,681.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,445,326,579.00	1,445,326,579.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-122,022,079.40	-208,227,783.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,168,083.30	133,168,083.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-108,905,345.51	-133,168,083.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,999,178.55	179,598,695.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	-126,434,065.41	-119,683,648.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	171,716,717.31	170,597,616.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,302,790.53	-96,217,082.04
39217	Ном	24,736,504.00	26,680,304.00
393	Биет бус хөрөнгө	633,224,650.86	624,286,109.28
39301	Программ хангамж	16,525,000.00	16,525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,586,458.42	-16,525,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	624,286,109.28	624,286,109.28
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,324,406,255.44</u>	<u>2,183,663,726.08</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>63,403.77</u>	<u>11,924,268.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	63,403.77	11,924,268.00
413	Өглөг	63,403.77	11,924,268.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	43,574.97	00.00
4136	Бусад өглөг	19,828.80	11,924,268.00
41361	Байгууллагад төлөх өглөг	19,828.80	11,924,268.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,324,342,851.67</u>	<u>2,171,739,458.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,324,342,851.67	2,171,739,458.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,198,901,961.28	1,198,901,961.28
51101	Өмч: - төрийн	1,198,901,961.28	1,198,901,961.28
512	Хуримтлагдсан үр дүн	-379,234,036.41	-531,837,430.00
51210	Өмнөх үеийн үр дүн	-379,234,036.41	-379,234,036.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-152,603,393.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,504,674,926.80	1,504,674,926.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,324,406,255.44</u>	<u>2,183,663,726.08</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,083,044,707.00	1,196,241,204.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,824,821.00	16,817,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,566,779.00	11,860,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,566,779.00	11,860,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,544,996.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,473,788.00	11,510,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,547,995.00	00.00
122	Тусламжийн орлого	13,258,042.00	4,956,800.00
122001	Хандив тусламж /дотоод/	13,258,042.00	4,956,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,044,219,886.00	1,179,423,504.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,040,469,200.00	945,961,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,040,469,200.00	945,961,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,750,686.00	8,846,504.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,750,686.00	8,846,504.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	224,615,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	224,615,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,231,815,706.26	1,389,644,597.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,231,815,706.26	1,389,644,597.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,154,914,267.51	1,243,202,932.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	602,042,969.60	660,125,245.63
210101	Үндсэн цалин	406,059,254.00	454,555,787.97
210102	Нэмэгдэл	152,022,949.60	134,244,027.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,294,000.00	25,558,143.29
210104	Урамшуулал	24,666,766.00	45,767,287.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,703,546.90	85,014,970.94
210201	Тэтгэврийн даатгал	56,777,444.05	60,313,316.10
210202	Тэтгэмжийн даатгал	6,243,029.89	6,481,346.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,863,383.46	5,000,277.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,155,885.56	1,196,399.55
210205	Эрүүл мэндийн даатгал	11,663,803.94	12,023,631.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,350,009.75	185,985,768.00
210301	Гэрэл, цахилгаан	20,730,649.75	33,468,500.00
210302	Түлш, халаалт	164,271,360.00	145,092,268.00
210303	Цэвэр, бохир ус	6,348,000.00	7,425,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,712,209.00	29,821,875.00
210401	Бичиг хэрэг	2,426,430.00	4,884,831.00
210402	Тээвэр, шатахуун	7,274,523.00	8,684,304.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,592,085.00	5,301,070.00
210404	Ном, хэвлэл	00.00	167,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,516,190.00	1,312,290.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,902,981.00	9,472,380.00
2105	Норматив зардал	14,419,818.00	39,463,433.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	743,500.00	257,953.41
210502	Хоол, хүнс	12,651,018.00	35,221,180.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,025,300.00	3,984,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,328,888.00	7,034,480.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,215,000.00
210604	Урсгал засвар	32,328,888.00	5,819,480.00
2107	Томилолт, зочны зардал	404,000.00	3,027,000.00
210702	Дотоод албан томилолт	404,000.00	3,027,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,912,380.00	4,932,798.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	870,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,419,200.00	2,419,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	428,800.00	347,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,300.00	200,248.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	182,960.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	606,860.00	387,000.00
210807	Газрын төлбөр	19,260.00	217,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	347,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	193,040,446.26	227,797,361.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,894,000.00	45,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,515,922.00	32,856,020.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	148,630,524.26	149,441,341.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,901,438.75	146,441,665.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,086,190.00	40,881,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,670,800.00	7,433,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,235,390.00	33,448,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,180,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,815,248.75	105,560,365.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,815,248.75	105,560,365.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-148,770,999.26	-193,403,393.59
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,757,000.00	40,800,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	14,757,000.00	40,800,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	14,757,000.00	40,800,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-134,013,999.26	-152,603,393.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,052,620,282.00</u>	<u>1,179,773,504.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,000,396.00	350,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,000,396.00	350,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,000,396.00	350,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,000,396.00	350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,043,619,886.00	1,179,423,504.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,040,469,200.00	945,961,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,040,469,200.00	945,961,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,150,686.00	8,846,504.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,150,686.00	8,846,504.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	224,615,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	224,615,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,052,620,282.00</u>	<u>1,176,191,604.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,052,620,282.00	1,176,191,604.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	975,931,843.25	1,029,749,938.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	602,042,973.60	660,125,245.63
210101	Үндсэн цалин	374,063,419.00	454,449,055.43
210102	Нэмэгдэл	167,097,120.60	134,350,759.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,813,225.00	25,558,143.29
210104	Урамшуулал	35,069,209.00	45,767,287.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,703,543.90	85,014,970.94
210201	Тэтгэврийн даатгал	56,652,362.60	60,313,316.10
210202	Тэтгэмжийн даатгал	6,202,463.73	6,481,346.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,854,510.93	5,000,277.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,171,980.40	1,196,399.55
210205	Эрүүл мэндийн даатгал	11,822,226.24	12,023,631.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,350,009.75	174,061,500.00
210301	Гэрэл, цахилгаан	20,730,649.75	33,468,500.00
210302	Түлш, халаалт	164,271,360.00	133,168,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,348,000.00	7,425,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,399,120.00	22,194,284.00
210401	Бичиг хэрэг	2,583,300.00	3,252,400.00
210402	Тээвэр, шатахуун	6,202,053.00	8,496,804.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,592,085.00	5,301,070.00
210404	Ном, хэвлэл	00.00	87,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,816,200.00	2,617,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,205,482.00	2,439,710.00
2105	Норматив зардал	16,103,720.00	39,549,010.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	675,500.00	856,600.00
210502	Хоол, хүнс	12,847,500.00	33,921,210.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,580,720.00	4,771,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,516,616.00	9,825,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,499,930.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	4,310,000.00
210604	Урсгал засвар	29,016,686.00	5,515,300.00
2107	Томилолт, зочны зардал	404,000.00	3,027,000.00
210702	Дотоод албан томилолт	404,000.00	3,027,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,077,880.00	5,397,228.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	419,200.00	861,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,419,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	428,800.00	347,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,300.00	209,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	182,960.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	772,360.00	851,430.00
210807	Газрын төлбөр	19,260.00	217,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	347,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,333,980.00	30,555,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,333,980.00	30,555,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,688,438.75	146,441,665.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,873,190.00	40,881,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,670,800.00	7,433,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,222,390.00	33,448,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,815,248.75	105,560,365.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,815,248.75	105,560,365.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	3,581,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	3,581,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	3,581,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	3,581,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,581,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-3,581,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.14	-272,562,563.97	737,526,715.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.14	-272,562,563.97	737,526,715.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	624,286,109.28	00.00	-27,912,543.01	596,373,566.27
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-379,234,036.41	2,324,342,851.67
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-379,234,036.41	2,324,342,851.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-379,234,036.41	2,324,342,851.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-152,603,393.59	-152,603,393.59
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	-531,837,430.00	2,171,739,458.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	945,961,300.00	844,092,767.85	101,868,532.15	89.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	945,961,300.00	844,092,767.85	101,868,532.15	89.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	904,105,700.00	803,211,467.85	100,894,232.15	88.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	699,081,800.00	618,906,692.75	80,175,107.25	88.53
210101	Үндсэн цалин	477,098,900.00	418,125,733.49	58,973,166.51	87.64
210102	Нэмэгдэл	148,992,700.00	130,136,528.70	18,856,171.30	87.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,888,100.00	24,877,143.29	9,010,956.71	73.41
210104	Урамшуулал	39,102,100.00	45,767,287.27	(6,665,187.27)	117.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,385,200.00	79,736,457.10	7,648,742.90	91.25
210201	Тэтгэврийн даатгал	62,983,100.00	56,481,935.49	6,501,164.51	89.68
210202	Тэтгэмжийн даатгал	6,100,500.00	6,116,413.45	(15,913.45)	100.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,880,400.00	4,711,690.70	168,709.30	96.54
210204	Ажилгүйдлийн даатгал	1,220,100.00	1,124,252.90	95,847.10	92.14
210205	Эрүүл мэндийн даатгал	12,201,100.00	11,302,164.56	898,935.44	92.63
2104	Хангамж, бараа материалын зардал	20,709,800.00	20,445,780.00	264,020.00	98.73
210401	Бичиг хэрэг	3,252,400.00	3,252,400.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,311,300.00	5,311,300.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,478,900.00	5,301,070.00	177,830.00	96.75
210404	Ном, хэвлэл	1,524,000.00	1,524,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,617,300.00	2,617,300.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,525,900.00	2,439,710.00	86,190.00	96.59
2105	Норматив зардал	50,721,000.00	39,549,010.00	11,171,990.00	77.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	856,600.00	856,600.00	-	100.00
210502	Хоол, хүнс	44,994,300.00	33,921,210.00	11,073,090.00	75.39
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,870,100.00	4,771,200.00	98,900.00	97.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,428,000.00	4,310,000.00	118,000.00	97.34
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,428,000.00	4,310,000.00	118,000.00	97.34
2107	Томилолт, зочны зардал	4,197,000.00	3,027,000.00	1,170,000.00	72.12
210702	Дотоод албан томилолт	4,197,000.00	3,027,000.00	1,170,000.00	72.12
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,882,600.00	4,536,228.00	346,372.00	92.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,419,200.00	80,800.00	96.77
210803	Даатгалын үйлчилгээ	479,300.00	347,850.00	131,450.00	72.57
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,300.00	209,748.00	45,552.00	82.16
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	143,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	940,000.00	851,430.00	88,570.00	90.58
210807	Газрын төлбөр	217,200.00	217,200.00	-	100.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	347,800.00	347,800.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32700300.00	32700300.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,700,300.00	32,700,300.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,855,600.00	40,881,300.00	974,300.00	97.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,855,600.00	40,881,300.00	974,300.00	97.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,433,100.00	7,433,100.00	-	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,448,200.00	33,448,200.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	974,300.00	00.00	974,300.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	946,311,300.00	946,311,300.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	945,961,300.00	945,961,300.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	945,961,300.00	945,961,300.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	350,000.00	350,000.00	-	100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	350,000.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	48.00	(2.00)	104.35
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	17.00	(2.00)	113.33

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,846,504.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,846,504.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,846,504.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,185,504.00
210402	Тээвэр, шатахуун	3,185,504.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,800,000.00
210604	Урсгал засвар	4,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	861,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	861,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,846,504.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,846,504.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,846,504.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь эрхэм зорилгоо “Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт дэвшилтэд технологи, ногоон ур чадварыг эзэмшсэн чадварлаг ажиллах хүчийг бэлтгэдэг СУРГАЛТ-ДАДЛАГА-ҮЙЛДВЭРЛЭЛ хосолсон магадлан итгэмжлэгдсэн сургууль болох” гэж тодорхойлсон.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь шинжлэх ухаан технологийн ололтод тулгуурлан сургалт, судалгаа, үйлдвэрлэлээр зах зээлийн эрэлт хэрэгцээг хангасан мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн чиглэлээр төрөлжсөн жишиг сургууль болох зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа
- Мэргэжлийн боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тушаал
- Захирлын 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн А/17 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг Боловсролын ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны ажлын төлөвлөгөөний дагуу тус байгууллагын 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд, Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2022 оны санхүүгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд тус тус дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,742.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	63.40	-	(63.40)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	161,835.42	161,302.93	(532.49)
Үндсэн хөрөнгө	2,162,507.43	2,022,360.79	(140,146.64)
Нийт хөрөнгийн дүн	2,324,406.25	2,183,663.72	(140,742.53)
Өглөг	63.40	11,924.26	11,860.86
Засгийн газрын хувь оролцоо	1,198,901.96	1,198,901.96	-
Хуримтлагдсан үр дүн	(379,234.04)	(531,837.43)	(152,603.39)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,504,674.93	1,504,674.93	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,324,406.25	2,183,663.72	(140,742.53)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 140,146.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 11,860.9 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,240,325.2 мянган төгрөгөөр тооцож төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, 1,230,467.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 35 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,230,467.9 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 984,817.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 224,615.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,171,577.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 350.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, урсгал зардалд 1,065,366.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 106,560.4 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,074,213.1 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 83,257.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 264.0 мянган төгрөг, норматив зардал 11,171.9 мянган төгрөг, Эд хогшил худалдан авах зардал 118.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 1,170.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 346.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71804-Тусгай мэргэжлийн боловсрол	1,120,738.40	1,179,573.50	(58,835.10)	105.25
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	859,111.40	870,086.94	(10,975.54)	101.28
1.2	80111-Төрийн байгууллагын тогтмол зардал	174,777.10	174,777.10	-	-
1.3	80112-Нийтлэг үйлчилгээ	-	49,838.60		
1.4	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	41,855.60	39,876.56	1,979.04	-
1.5	81806-Дотуур байрны хүүхдийн хоол	44,994.30	44,994.30	-	
Дүн		1,120,738.40	1,179,573.50	(58,835.10)	105.25

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 8,846.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, тээвэр шатахууны зардалд 3,185.5 мянган төгрөг, урсгал засварын зардалд 4,800.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 861.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх, батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулж, өр төлбөр үүсгэхгүй байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал, Н.Тэмүүжин нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 984,817.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,772.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох зардлыг хэмнэж цалин хөлс болон нэмэгдэл урамшил 83,257.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 264.0 мянган төгрөг, норматив зардал 11,171.9 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 118.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 1,170.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 346.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 171 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 125 мэдээллийг хугацаандаа, 42 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг мэдээлээгүй, цалингаас бусад 5 саяас дээш нийт 52,471.1 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг тус тус мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй болно.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 238,106.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 73,159.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 164,947.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 309.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 107,338.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Үүнээс 309.4 мянган төгрөгийн 2 төлбөрийг актыг бүрэн барагдуулж, 336.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 107,001.5 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд алдаа зөрчил давтан гарч байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Төлбөрийн акт	2	309.4	2	309.4	100
Зөвлөмж	5	107,338.3	2	336.8	40
Нийт дүн	7	107,647.7	4	646.2	70

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 164,947.0 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 212.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 146,877.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, 17,857.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 212.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд 1 албан хаагчид удирдлагын тушаал шийдвэрээр баталсан хувь хэмжээг нэмэгдүүлэн 27.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон нэмэгдэл цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд давхар хөдөлмөр эрхэлдэг 3 албан хаагчид ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас гарт олгох цалинг 184.6 мянган төгрөгөөр илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 146,877.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 118 нэр төрлийн 120,271.2 мянган төгрөгийн биет хөрөнгө, 3 нэр төрлийн 870.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Бараа материалын дансанд 28 нэр төрлийн 25,735.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмж бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: УСНББОУС 12, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас

баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны батлагдсан орон тоо 46, гүйцэтгэлээр 48 орон тоотой ажиллаж батлагдсан орон тоог 2 орон тоогоор хэтрүүлэн ажилласан нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,980.9 мянган төгрөгийн хөрөнгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад нийт 3 байгууллагын 2,952.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд 11,924.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны үндсэн хөрөнгийн ажил гүйлгээг шалгахад 162 нэр төрлийн 1,752,553.3 мянган төгрөгийн хөрөнгийн 73,159.0 мянган төгрөгийн элэгдлийг дутуу тооцож тайлагнасан	1	73,159.0	1	73,159.0	-	-	1	73,159.0	-	-	-	-
Дүн	1	73,159.0	1	73,159.0	-	-	1	73,159.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд 1 албан хаагчид удирдлагын тушаал шийдвэрээр баталсан хувь хэмжээг нэмэгдүүлэн 27.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин илүү олгосон	1	27.7	1	27.7	-	-	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд давхар хөдөлмөр эрхэлдэг 3 албан хаагчид ХХОАТ-ыг давхардуулан тооцсоны улмаас гарт олгох цалинг 184.6 мянган төгрөгөөр илүү олгосон	1	184.6	1	184.6	-	-	-	-	-	-	-	-
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 118 нэр төрлийн 120,271.2 мянган төгрөгийн биет хөрөнгө, 3 нэр төрлийн 870.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	121,141.2			1	121,141.2	-	-	-	-	-	-
Бараа материалын дансанд 28 нэр төрлийн 25,735.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмж бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	25,735.8			1	25,735.8	-	-	-	-	-	-
Тайлант оны батлагдсан орон тоо 46, гүйцэтгэлээр 48 орон тоотой ажиллаж батлагдсан орон тоог 2	1	-			1	-	-	-	-	-	-	-

орон тоогоор хэтрүүлэн ажилласан												
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,980.9 мянган төгрөгийн хөрөнгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас бэлтгэсэн	1	2,980.9	-	-	-	-	1	2,980.9	-	-	-	-
Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад нийт 3 байгууллагын 2,952.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй	1	2,952.4	-	-	-	-	1	2,952.4	-	-	-	-
Тайлант онд 11,924.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй	1	11,924.3	-	-	-	-	1	11,924.3				
Дүн	8	164,947.0	2	212.4	3	146,877.0	3	17,857.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 125 мэдээллийг хугацаандаа, 42 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг мэдээлээгүй, цалингаас бусад 5 саяас дээш нийт 52,471.1 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг тус тус мэдээлээгүй	1	52,471.1	-	-	1	52,471.1	-	-	-	-
Дүн	1	52,471.1	-	-	1	52,471.1	-	-	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn